

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХУУЛИЙН ХЭЛТЭС**

**ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ТАЛААР
/шинэчилсэн найруулга/**

2020 он

ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬ

/Шинэчилсэн найруулга/

Нэг.Оршил

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан бөгөөд 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Төрийн аудитын тухай хууль нь 6 бүлэг, 43 зүйлтэй.

Хоёр: Хуулийн агуулга

Монгол Улсын Их Хурал 2003 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Төрийн аудитын тухай хуулийг баталсан бөгөөд өнгөрсөн хугацаанд тус хуульд 10 удаа нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга, үзэл санаанд холбогдох хууль тогтоомжийг нийцүүлж, эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Улсын Их Хурлаас 2020 оны 02 дугаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолыг баталсан. Тус тогтоолын хавсралтын 1.2.5-д “төрийн санхүү, төсвийн хяналт /аудит/-ыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоох;”, 1.2.6-д “төрийн нийтийн өмчийг зохистой ашиглах, зарцуулахад тавих хяналтыг боловсронгуй болгох.” гэсэн үзэл баримтлалын чиглэл баримтлахаар тусгасан.

Дээрх үзэл баримтлалын хүрээнд “Төрийн аудитын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төслийн зохицуулах харилцааны товч утгыг “Төрийн аудитын байгууллагын бие даасан, үйл ажиллагааны хараат бус байдлыг сайжруулах, эрх хэмжээг нэмэгдүүлэх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн шинэчлэх.” хэмээн тодорхойлсон байна.

Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх, татвар болон татварын бус орлого, байгалийн баялгийн ашиглалтаас бүрдсэн нийтийн өмчийг зохистойгоор төлөвлөх, тайлагнах, ашиглах, зарцуулах үйл ажиллагаанд тавих хяналтын эрх зүйн үндсийг тогтоох зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж батлуулсан байна. Хуульд дараах асуудлыг шинээр тусгасан байна. Үүнд:

1.Төрийн аудитад хууль дээдлэх, хараат бус, бие даасан байх, шударга ёсыг хангах, мэдээллээр бүрэн хангагдах, ил тод, бодитой байх, төрийн аудитын олон улсын нийтлэг стандартад нийцсэн байх зарчмыг тусгаж, төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх эрх зүйн орчин бүрдүүлэх;

2.Нийтийн өмчийг хууль ёсны дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад хяналт тавих, түүнчлэн төрийн санхүүгийн удирдлага сайжрах үндэс бүрдүүлэх;

3.Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам тодорхой болж, төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд хамаарахгүй чиг үүргийг төрийн аудитын байгууллагад бусад хуулиар нэмэгдүүлэхгүй байх асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн боловсруулах;

4.Аудитын төлөвлөлт, төлөвлөгөөт бус аудит хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

5.Төрийн аудитын байгууллага үр дүнтэй, үр ашигтай аудит хийх шинжлэх ухааны ололт, орчин үеийн мэдээллийн технологийн арга, хэлбэрийг үйл

ажиллагаандаа нэвтрүүлэх, төрийн аудитын олон улсын стандартыг баримтлах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

6.Төрийн аудитын байгууллагын албан хаагч аудит хийх үедээ мэдээллээр бүрэн хангагдах зарчим тодорхой болж, шалгагдагч этгээдийн ажлын байр болон бусад холбогдох газарт ажлын цагаар саадгүй нэвтрэн орох, ажиллах, бүртгэл, тооллого хийх, мэдээлэл, баримт бичиг, бусад эд зүйлстэй үнэ төлбөргүй танилцах; шалгагдагч этгээдийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа тоног төхөөрөмж, программ хангамж, мэдээллийн санд нэвтрэх, цахим хэлбэрээр боловсруулсан, хадгалсан, илгээсэн, хүлээсэн авсан мэдээлэлтэй танилцах; тайлбар гаргуулах, тодорхой асуулт тавьж хариулт авах, хараат бус ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

7. Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар өгсөн албан шаардлага, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, төрийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн тохиолдолд тогтоосон төлбөрийн акт биелэгдэх эрх зүйн орчин тодорхой болгох;

8.Төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн хэрэгжилтийг мэдээлэх асуудлыг Үндэсний аудитын газрын цахим хуудаст байршуулж, олон нийт, иргэд нээлттэй танилцах боломжийг бий болгож, төрийн аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үйл ажиллагааг сайжруулах;

9.Монгол Улсын Ерөнхий аудиторыг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг, нэгжлэг хийх, хуульд зааснаас бусад үндэслэлээр Монгол Улсын Ерөнхий аудиторыг албан тушаалаас чөлөөлөх, огцруулах, түдгэлзүүлэх, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд томилох хууль зүйн баталгааг тодорхой болгох;

10.Төрийн аудитор бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулсан, аливаа дарамт, шахалт, хууль бус нөлөөллийн талаар нөлөөллийн мэдүүлэг хөтлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

11.Төрийн аудитын байгууллагын төсөв нь төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй байх эдийн засгийн баталгаа, албан хаагчдын нийгмийн баталгаатай холбогдсон харилцааг тодорхой болгох;

12.Нийтийн өмч, төсвийг ашиглах, зарцуулахдаа сахилга бат алдсан албан хаагчид хариуцлага тооцох механизмийг тодорхой болгох.

Төрийн аудитын тухай хуулийг 2003 онд баталснаас хойш нийт 10 удаа нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бөгөөд хуулийн 58 хувь нь өөрчлөгдөж, хуулийн бүтэц, нэр томъёо, хэсэг, заалт хоорондын уялдаа алдагдсан гэж хууль санаачлагч үзэн тус хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулан Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллагад өргөн мэдүүлж, Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар батлагдсан учир цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчтай холбоотой хэрэгжүүлэх зүйл, заалтаас түүвэрлэн энэхүү мэдээллийг боловсрууллаа.

Хуулийг <https://legalinfo.mn/law/details/15357?lawid=15357> холбоосоор орж дэлгэрэнгүй үзнэ үү.

ГАРЧИГ

Нэг. Оршил

Хоёр. Хуулийн агуулга

Гурав. Хуулийн бүтэц

Дөрөв. Хуулийн зарим зохицуулалтаас

Тав. Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу дагалдан гарах эрх зүйн актууд

Гурав:Хуулийн бүтэц

№	Бүлэг	Зохицуулсан харилцаа
1	Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 2 дугаар зүйл. Төрийн аудитын хууль тогтоомж 3 дугаар зүйл. Төрийн аудитын зарчим 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 5 дугаар зүйл. Төрийн аудитын үндсэн зорилт 6 дугаар зүйл. Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх
2	Хоёрдугаар бүлэг Төрийн аудитын үйл ажиллагаа	7 дугаар зүйл. Төрийн аудитын төрөл, хэлбэр 8 дугаар зүйл. Санхүүгийн тайлангийн аудит 9 дүгээр зүйл. Гүйцэтгэлийн аудит 10 дугаар зүйл. Нийцлийн аудит 11 дүгээр зүйл. Аудитын төлөвлөлт 12 дугаар зүйл. Төлөвлөгөөт бус аудит 13 дугаар зүйл. Аудитад цахим мэдээлэл, арга зүйг ашиглах 14 дүгээр зүйл. Төрийн аудитын стандарт 15 дугаар зүйл. Мэдээлэл авах эрх 16 дугаар зүйл. Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагчийн үүрэг 17 дугаар зүйл. Аудитад шинжээч оролцуулах 18 дугаар зүйл. Гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын тайлангийн төсөлд санал авах 19 дүгээр зүйл. Аудитад хамрагдагчийн тайлбар, саналыг сонсох 20 дугаар зүйл. Төрийн аудитын тайлан 21 дүгээр зүйл. Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох 22 дугаар зүйл. Албан шаардлага, төлбөрийн актыг мэдэгдэх 23 дугаар зүйл. Албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангах
3	Гуравдугаар бүлэг Төрийн аудитын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, бүрэлдэхүүн	24 дүгээр зүйл. Төрийн аудитын байгууллагын тогтолцоо 25 дугаар зүйл. Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын бүрэлдэхүүн, ангилал, зэрэг дэв 26 дугаар зүйл. Төрийн аудитын байгууллагын албан хаагчид тавих шаардлага 27 дугаар зүйл. Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн тангараг 28 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхий аудитор

		29 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхий аудиторын бүрэн эрх 30 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхий аудиторыг чөлөөлөх, огцруулах 31 дүгээр зүйл. Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн үүрэг 32 дугаар зүйл. Төрийн аудитын байгууллагад хийх аудит
4	Дөрөвдүгээр бүлэг Төрийн аудитын байгууллагаас бусад байгууллага, иргэдтэй харилцах, ил тод байдал	33 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхий аудитор Улсын Их Хуралтай харилцах 34 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхий аудитор Засгийн газартай харилцах 35 дугаар зүйл. Гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулах 36 дугаар зүйл. Төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн хэрэгжилтийг мэдээлэх 37 дугаар зүйл. Төрийн аудитын нээлттэй, ил тод байдлыг хангах
5	Тавдугаар бүлэг Төрийн аудитын баталгаа	38 дугаар зүйл. Хууль зүйн баталгаа 39 дүгээр зүйл. Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх 40 дүгээр зүйл. Эдийн засгийн баталгаа 41 дүгээр зүйл. Нийгмийн баталгаа
6	Зургадугаар бүлэг Бусад зүйл	42 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага 43 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

ДӨРӨВ:ХУУЛИЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТААС

Хуулийн зорилго /1 дүгээр зүйл/

Энэ хуулийн зорилго нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтооход оршино.

Төрийн аудитын зарчим /3 дугаар зүйл/

Төрийн аудитад хууль дээдлэх, хараат бус, бие даасан байх, шударга ёсыг хангах, мэдээллээр бүрэн хангагдах, ил тод, бодитой байх, төрийн аудитын олон улсын нийтлэг стандартад нийцсэн байх зарчмыг баримтална.

Хуулийн нэр томъёоны тодорхойлолт /4 дүгээр зүйл/

№	Нэршил	Тайлбар
1	Төрийн санхүү, төсвийн хяналт	Төрийн санхүү, төсөв, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, эргэн төлөгдөх нөхцөлөөр ашиглуулах үйл ажиллагаа, хувьчлал, дуудлага худалдаа, техник, эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, зээллэг, гадаад зээл, тусламж, хандив, санхүүгийн дэмжлэг, өрийн баталгаа, үнэт цаас, бүх төрлийн гэрээ, хэлцэл болон бусад аливаа үйл

		ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, ашиглалт, зарцуулалт, хэрэгжилт, тайлагнал болон нийтийн өмчтэй холбоотой бүх үйл ажиллагаанд төрийн аудит хийх.
2	Нийтийн өмч	Нийтийн ашиг сонирхлын төлөө ашиглагдах иргэдэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, түүний баялаг, ой, ус, ургамал, ан амьтны нөөц, эрдэнэсийн сан, төсвийн орлого, нийтийн болон тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчид хамаарах эдийн болон эдийн бус хөрөнгө, хуулиар нийтийн зориулалтаар ашиглах өмчид хамаарах бусад хөрөнгө.
3	Төрийн аудитын байгууллага	Төрийн аудит хийх чиг үүрэг бүхий Үндэсний аудитын газар, аймаг, нийслэл дэх төрийн аудитын газар, төрийн аудитын байгууллагын албан хаагч.
4	Шалгагдагч этгээд	Төсвийн байгууллага, тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд болон хуульд заасны дагуу төрийн аудит хийгдэх аливаа этгээд.
<i>Энэ заалтын “аливаа этгээд” гэснийг шалгагдагч этгээд тэдгээрийн холбогдох албан тушаалтныг ойлгоно.</i>		
5	Аудитад хамрагдагч	Шалгагдагч этгээдтэй санхүү, эдийн засгийн харилцаанд оролцсон этгээд.
6	Аудитын тайлан	Аудитын төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын дүнг илтгэсэн, эрх бүхий албан тушаалтны баталгаажуулсан баримт бичиг.
7	Аудитын төлөвлөгөө	Аудит хийх үндэслэл, аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй, цаг хугацаа, хөтөлбөрийг багтаасан эрх бүхий этгээдийн баталсан баримт бичиг.
8	Санхүүгийн тайлангийн аудит	Шалгагдагч этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажуулах.
9	Гүйцэтгэлийн аудит	Шалгагдагч этгээдийн бодлого, тогтолцоо, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үйл явц, үр дүн, гүйцэтгэлд аудит хийх ажиллагаа.
10	Нийцлийн аудит	Шалгагдагч этгээдийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэлд аудит хийх ажиллагаа.
11	Аудитын хуулийн этгээд	Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нөхөрлөл, компань.
12	Лог бүртгэл	Хэрэглэгч программд нэвтэрсэн, үйлдэл хийсэн, өөрчлөлт хийсэн, өөрчлөлт хийхийг завдсан үйлдлийн түүх.
13	Нөлөөллийн мэдүүлэг	Аудит хийх явцад тухайн аудитын үр дүнтэй холбогдуулан төрийн аудитын байгууллагад аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх гэж оролдсон бүх үйлдлийг тэмдэглэн баталгаажуулсан баримт бичиг.

Төрийн аудитын үндсэн зорилт /5 дугаар зүйл/

Төрийн аудитын үндсэн зорилт нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг хууль ёсны дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад хяналт тавих, түүнчлэн төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх /6 дугаар зүйл/

1/Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын¹ дагуу төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллага нь төрийн аудитын байгууллага байна.

2/Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг зөвхөн энэ хуулиар тогтоох бөгөөд бусад хуулиар төрийн аудитын байгууллагад Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиар тодорхойлсон төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд хамаарахгүй чиг үүрэг нэмэгдүүлэхийг хориглоно.

№	Эдлэх эрх	
1	Төрийн аудитын байгууллага дараах бүрэн эрх	Шалгагдагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх
2		Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/-аас Монгол Улсын Их Хурал /цаашид “Улсын Их Хурал” гэх/-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх
3		Төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд хуульд заасан болон шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар аудит хийх
4		Нийтийн өмчтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актыг боловсронгуй болгох, батлан гаргах талаар эрх бүхий этгээдэд зөвлөмж өгөх

4/Гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын гүйцэтгэх ажилд зориулсан улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад Монгол Улсын Ерөнхий аудиторын санал болгосноор Улсын Их Хурлын даргаас итгэмжилсэн аудитор аудит хийх бөгөөд уг аудитыг гүйцэтгэх журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

5/Улсын Их Хурлаас хүсэлт гаргасан тохиолдолд Улсын Их Хурлын үйл ажиллагаанд бусад төрөл, хэлбэрээр аудит хийж болно.

6/Аудитад хамрагдагчийн шалгагдагч этгээдтэй санхүү, эдийн засгийн харилцаанд оролцсон тухайн үйл ажиллагаа төрийн аудитад хамрагдана.

7/Энэ хуулийн 6.3.3-т заасан эрхийг /Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх/ хэрэгжүүлэхэд энэ хуулийн 12.1 дэх хэсэг /Төрийн аудитын байгууллага төлөвлөгөөт бус аудитыг Улсын Их Хурлын шийдвэр, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан Хянан шалгах түр хорооны шийдвэр болон хуульд заасан бусад үндэслэлээр хийнэ/ хамаарахгүй.

¹ Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. Монгол Улсын Үндсэн хуулийн Хоринтавдугаар зүйлийн 7 дахь хэсэг.

Төрийн аудитын төрөл, хэлбэр /7 дугаар зүйл/

1/Төрийн аудитын байгууллага төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд дараах төрлөөр аудит хийнэ:

Санхүүгийн тайлангийн аудит

Гүйцэтгэлийн аудит

Нийцлийн аудит

2/Төрийн аудитын байгууллага энэ хуулийн 7.1-д заасан аудитыг нэгдсэн, хамтарсан, зэрэгцээ, баталгаажуулах, мэдээллийн технологийн болон бусад хэлбэрээр хийж болно.

3/Санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

Санхүүгийн тайлангийн аудит /8 дугаар зүйл/

1/Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, **төрийн** болон орон нутгийн **өмчит**, тэдгээрийн оролцоотой **хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит** хийнэ.

2/Төрийн аудитын байгууллага төрийн чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээдийн санхүүгийн тайланд аудит хийж болно.

3/Төрийн аудитын байгууллага Улсын Их Хурлын зөвхөн санхүүгийн тайланд аудит хийнэ.

4/Төрийн аудитын байгууллага энэ хуульд заасан санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

5/Аудитын хуулийн этгээд энэ хуулийн 8.4-т заасны дагуу санхүүгийн тайлангийн аудит хийхдээ төрийн аудитын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллана.

6/Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит хийхэд гарсан шууд ба шууд бус зардлыг нөхөх зорилгоор шалгагдагч этгээдээс аудитын үйлчилгээний төлбөр авна. Аудитын үйлчилгээний төлбөрийн жишиг үнийг Монгол Улсын Ерөнхий аудиторовын саналыг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтоож, холбогдох байгууллагуудын төсөвт тусгана.

7/Энэ хуулийн 8.4-т заасан аудитын хуулийн этгээдийг хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулах бөгөөд аудитын хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

Гүйцэтгэлийн аудит /9 дүгээр зүйл/

1/Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээдийн бодлого, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний **гүйцэтгэл нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй эсэхэд** аудит хийнэ.

2/Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээдийн тогтолцоо, үйл ажиллагааны зохион байгуулалт, түүний хэмжилт, дотоод хяналт үр нөлөөтэй эсэхэд дүгнэлт өгч, тэдгээрийг сайжруулах чиглэлээр гүйцэтгэлийн аудит хийнэ.

Нийцлийн аудит /10 дугаар зүйл/

1/Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээд үйл ажиллагаандаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой **хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актыг хэрэгжүүлж байгаа эсэхэд** аудит хийнэ.

2/Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээдийн мөрдөж байгаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын нийцэлд аудит хийнэ.

3/Төрийн аудитын байгууллага нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн аудиттай хослуулан хийж болно.

Аудитын төлөвлөлт /11 дүгээр зүйл/

1/Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын сэдвийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

2/Нэг дэх хэсэгт заасан аудитын сэдвийг дараах байдлаар ангилна:

1.хуульд заасны дагуу хийгдэх аудит;

2.төрийн аудитын байгууллагын бодлогоор хийгдэх аудит.

3/Хоёрдахь хэсэгт зааснаас бусад аудитын сэдвийг батлахдаа дараах хүчин зүйлд үндэслэнэ:

1.тухайн сэдвээр урьдчилсан судалгаа, тооцоолол хийгдсэн байх;

2.төсөв, санхүү, хугацаа болон хүний нөөцийн чадавхтай байх;

3.иргэд, олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал байх.

4/Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар тухайн орон нутагтаа гүйцэтгэх дөрвөөс илүүгүй аудитын сэдвийг энэ хуулийн 11.3-т заасан хүчин зүйлийг үндэслэн боловсруулж, Монгол Улсын Ерөнхий аудиторoor батлуулна.

5/Нэг болон дөрөвдэх хэсэгт заасан аудитын сэдвийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын төлөвлөгөөг жилийн болон хэтийн хугацаагаар боловсруулж батална.

Төлөвлөгөөт бус аудит /12 дугаар зүйл/

1/Төрийн аудитын байгууллага төлөвлөгөөт бус аудитыг Улсын Их Хурлын шийдвэр, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан Хянан шалгах түр хорооны шийдвэр болон хуульд заасан бусад үндэслэлээр хийнэ.

Тайлбар:-Энэ хэсгийн “хуульд заасан бусад үндэслэл” гэснийг Нийтийн сонсголын тухай хуулийн 9.2-т “Төсвийн хяналтын сонсгол явуулах бол төрийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна” гэх зэргээр хуульд тусгайлан заасан асуудлаар төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэхээр заасан тохиолдлыг ойлгоно.

2/Энэ хуулийн 12.1-д заасны дагуу холбогдох этгээд төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэх тохиолдолд энэ талаар Монгол Улсын Ерөнхий аудиторт урьдчилан мэдэгдэж, зөвшилцсөний үндсэн дээр уг аудитын хамрах хүрээ, хугацааг тогтооно.

Төрийн аудитын стандарт /14 дүгээр зүйл/

1/Төрийн аудитын байгууллага чиг үүргээ гүйцэтгэхдээ Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын байгууллагаас хүлээн зөвшөөрсөн төрийн аудитын

олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий этгээдээс баталсан стандартыг баримтална.

2/Үндэсний аудитын газрын дэргэд төрийн аудиттай холбоотой стандарт, аргачлал, удирдамж, зааврыг боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус гишүүдээс бүрдсэн Төрийн аудитын стандартын хороо ажиллана.

3/Төрийн аудитын стандартын хороо Монгол Улсын Ерөнхий аудиторын шийдвэрээр томилогдсон эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэл, эрх зүйн болон бусад чиглэлээр мэргэшсэн 9-өөс доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

4/Төрийн аудитын стандартын хороо дараах чиг үүрэгтэй:

1.төрийн аудитын олон улсын стандартын албан орчуулгыг хянан, хэрэглээний тайлбар, зөвлөмж гаргах;

2.төрийн аудитын үндэсний стандарт боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.төрийн аудитын байгууллагаас аудит хийхтэй холбоотой дотоод аргачлал, удирдамж, заавар гаргах.

5/Төрийн аудитын стандартын хорооны дүрэм, хорооны гишүүдэд олгох урамшууллын хэмжээг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

Мэдээлэл авах эрх /15 дугаар зүйл/

1/Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ мэдээллээр бүрэн хангагдах зарчмын хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

№	Эдлэх эрх	
1	Мэдээлэл авах эрх	Шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хэлбэрээс нь үл хамааран шалгагдагч этгээд, аудитад хамрагдагч болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнаас тогтоосон хугацаанд, үнэ төлбөргүйгээр гаргуулах, хуулбарлаж авах.
2		Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагчийн ажлын байр болон бусад холбогдох газарт ажлын цагаар саадгүй нэвтрэн орох, ажиллах, бүртгэл, тооллого хийх, мэдээлэл, баримт бичиг, аливаа эд зүйлстэй үнэ төлбөргүйгээр танилцах.
3		Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагчийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа тоног төхөөрөмж, программ хангамж, түүний эх код, цахим мэдээллийн сан, лог бүртгэлд нэвтрэх, цахим хэлбэрээр боловсруулсан, хадгалсан, илгээсэн, хүлээн авсан мэдээлэл, баримт бичигтэй танилцах, уг мэдээлэл, баримт бичгийг цахим болон бусад хэлбэрээр хувиран авах.
4		Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагчаас тайлбар гаргуулах, тодорхой асуулт тавьж, хариулт авах.
5		Энэ хуулийн 13.2-т заасан системийн мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор төрийн бусад байгууллагын цахим систем болон цахим хэлбэрээр бүрдүүлсэн мэдээллийн сангаас аудитад шаардлагатай мэдээллийг гаргуулах.

2/Энэ хуулийн 6.4-т зааснаас бусад тохиолдолд төрийн аудитын байгууллага аудит хийхдээ зөвхөн Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний эрх олгосон төрийн аудитын байгууллагын албан хаагч төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл, баримт бичиг, түүнчлэн шалгагдагч этгээдтэй санхүү, эдийн засгийн харилцаанд оролцсон байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл, баримт бичгийн зөвхөн тухайн харилцаатай холбогдох хэсэгтэй хуульд заасан журмын дагуу танилцах, хэвлэх, олшруулж авах эрхтэй.

3/Төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл, баримт бичигтэй танилцсан төрийн аудитын байгууллагын албан хаагч уг мэдээлэл, баримт бичгийг холбогдох хуульд заасны дагуу нууцлах үүрэг хүлээнэ.


4/Энэ хуулийн 15.2-т заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулах, аудитад шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг нуун дарагдуулахыг хориглоно.

5/Төрийн аудитын байгууллагын мэдээлэл авах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагчийн үүрэг /16 дугаар зүйл/

№	Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагчийн үүрэг
1	Төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах
2	Төрийн аудитын байгууллагын албан хаагчийг ажлын байр, холбогдох бусад газар, цахим мэдээллийн санд чөлөөтэй нэвтрүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах
3	Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохгүй байх;
4	Төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх;
5	Төрийн аудитын байгууллагын албан хаагчтай харилцах, туслах үүргийг тодорхой ажилтанд хариуцуулах;
6	Хуульд заасан бусад үүрэг.

Гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын тайлангийн төсөлд санал авах /18 дугаар зүйл/



Шалгагдагч этгээд энэ хуулийн 10 хоногийн дотор аудитын тайлангийн төсөлд санал ирүүлээгүй бол саналгүйд тооцно.

Төрийн аудитын тайлан /20 дугаар зүйл/

1/Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын **тайлан** гаргана.

2/Төрийн аудитын байгууллага аудитын дүгнэлтэд тулгуурлан төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актын хүрээнд нийтийн өмчийг төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулах үйл ажиллагааны арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдал болон төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтанд **зөвлөмж** өгнө.

3/Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.

4/Төрийн аудитын байгууллага аудитын тайланг шалгагдагч этгээд, Улсын Их Хурал, шаардлагатай тохиолдолд Засгийн газар болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох /21 дүгээр зүйл/

1/Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан **шаардлага** өгнө.

2/Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол **төлбөрийн акт** тогтооно.

3/Төрийн аудитын байгууллага энэ хуулийн 21.1, 21.2-т заасны дагуу өгсөн **албан шаардлага**, тогтоосон **төлбөрийн акт** нь аудитын тайлангийн салшгүй хэсэг байна.

4/Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

Төрийн аудитын байгууллагын тогтолцоо /24 дүгээр зүйл/

24.1.Төрийн аудитын байгууллага нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх бөгөөд төрийн аудитын дээд байгууллага буюу **Үндэсний аудитын газар**, түүний харьяа аймаг, нийслэл дэх **Төрийн аудитын газраас** бүрдэнэ. Монгол Улсын Ерөнхий аудитор энэ хуулийн 24.2-т заасны дагуу батлагдсан орон тооны дээд хязгаарт багтаан аудитын онцлогийг харгалзан төрөлжсөн аудитын газар байгуулж болно.

24.2.Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг Монгол Улсын Ерөнхий аудиторын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо батлах бөгөөд уг орон тоо нь төрийн аудитын байгууллага чиг үүргээ тогтоосон цаг хугацаанд бүрэн хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц байна.

24.3.Монгол Улсын Ерөнхий аудитор энэ хуулийн 24.2-т заасны дагуу батлагдсан орон тооны дээд хязгаарыг үндэслэн төрийн аудитын байгууллагын зохион байгуулалт, бүтэц, түүний чиг үүрэг, орон тоог батална.

24.4.Үндэсний аудитын газрын дэргэд төрийн аудитын байгууллагын албан хаагчийг мэргэшүүлэх, аудиттай холбогдсон судалгаа, шинжилгээ хийх, аудитын

чадавхыг бэхжүүлэх чиг үүрэг бүхий сургалт, мэдээлэл технологийн төвтэй байж болно.

24.5.Төрийн аудитын байгууллага бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний тодорхойлолт, загвар, хэрэглэх журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

24.6.Төрийн аудитын байгууллага тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын бүрэлдэхүүн, ангилал, зэрэг дэв /25 дугаар зүйл/


№	Албан тушаалын ангилал	Албан хаагч
1	Төрийн аудитын тэргүүн түшээ	Монгол Улсын ерөнхий аудитор
2	Төрийн аудитын шадар түшээ	Монгол Улсын ерөнхий аудиторовын орлогч
3	Төрийн аудитын итгэмжит түшээ	Төрийн аудитын байгууллагын тэргүүлэх аудитор
4	Төрийн аудитын зөвлөх түшээ	Аудитын менежер
5	Төрийн аудитын ахлах түшээ	Ахлах аудитор Ахлах шинжээч
6	Төрийн аудитын түшээ	Аудитор Шинжээч
Төрийн тусгай албан хаагч байна.		

1/Энэ хуулийн 25.2-т заасан төрийн аудитын байгууллагын албан тушаалын ангилал тус бүрдээ тэргүүн зэрэг, дэд зэрэг, гутгаар зэрэг, дөтгөөр зэрэг гэсэн зэрэг дэвтэй байна.

2/Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхийлөгч, бусад албан хаагчийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхий аудитор олгоно.

3/Төрийн аудитын байгууллагын албан тушаалын зэрэг дэв, нэмэгдэл олгох журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор тогтооно.

Монгол Улсын Ерөнхий аудитор /28 дугаар зүйл/



№	Тавигдах шаардлага
1	Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлага
2	45 нас хүрсэн байх
3	Эдийн засаг, санхүү, эсхүл хууль зүйн чиглэлээр дээд боловсролын зэрэгтэй байх;
4	Төрийн албаны эрхэлсэн түшмэлээс дээш ангиллын албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан байх;
5	Сүүлийн зургаан жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй байх;
6	Монгол Улсын Ерөнхий аудиторовын бүрэн эрхэд харшлах ажил, албан тушаал давхар эрхэлдэггүй, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, мэргэжлийн болон төрийн бус байгууллагад ашиг сонирхлын зөрчилгүй байх.

Монгол Улсын Ерөнхий аудиторын бүрэн эрх /29 дүгээр зүйл/

№	Бүрэн эрх
1	Төрийн аудитын байгууллагыг нэгтгэн зохион байгуулж, удирдах
2	Төрийн аудитын байгууллагыг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;
3	Бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар, аргачлал, стандарт батлах;
4	Аудитын төлөвлөгөөг батлах;
5	Төрийн аудитын байгууллагын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих;
6	Улсын Их Хурлын чуулганы болон Засгийн газрын хуралдаанд зөвлөх эрхтэй оролцох;
7	Хуульд заасны дагуу төрийн аудитын байгууллагын албан хаагчийг томилох, чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, зэрэг дэв олгох, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах;
8	Аудитын бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр ажлын хэсэг байгуулах;
9	Аудитын тайланг баталгаажуулах;
10	Энэ хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд аудит, захиргаа, боловсон хүчин, санхүүгийн үйл ажиллагааг чиглүүлж шийдвэр гаргах;
11	Төрийн аудитын байгууллагын албан хаагчид зориулсан байнгын сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
12	Хуульд заасан бусад бүрэн эрх.

Монгол Улсын Ерөнхий аудиторыг чөлөөлөх, огцруулах /30 дугаар зүйл/

№	Чөлөөлөх тохиолдол
1	Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;
2	Албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан;
3	Биеийн эрүүл мэндийн шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;
4	Монгол Улсын харьяатаас гарсан, эсхүл гадаад улсын нутаг дэвсгэрт байнга оршин суух эрх авсан;
5	Өөрийнх нь зөвшөөрснөөр өөр ажил, албан тушаалд томилсон, хуульд заасны дагуу сонгогддог албан тушаалд нэр дэвшсэн;
6	Иргэний эрх зүйн чадамжийг нь хязгаарласан, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;
7	Нас барсан, эсхүл нас барсан болон сураггүй алга болсонд тооцох тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.
Огцруулах тохиолдол	
1	Хуулиар хориглосон ажил, албан тушаалыг давхар эрхэлсэн;
2	Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон;
3	Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг авах тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.

Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн үүрэг /31 дүгээр зүйл/

№	Хүлээх үүрэг
1	Шалгагдагч этгээдэд аудитын төрөл, зорилго, аудит хийх хамрах хүрээ, хугацаа, талуудын эрх, үүргийн талаар танилцуулах;
2	Энэ хуулийн 18.1-д зааснаас бусад тохиолдолд аудитын тайланг баталгаажих хүртэл аудитын ажлын үр дүнг хамгаалж бусдад задруулахгүй байх;
3	Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх;
4	Хуульд заасан бусад үүрэг.

Гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулах /35 дугаар зүйл/

1/Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор энэ тухай **прокурорын байгууллагад мэдэгдэж** эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох

мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ. Прокурорын байгууллага Ерөнхий аудитораас шилжүүлсэн мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар Ерөнхий аудиторт хариу мэдэгдэнэ.

Төрийн аудитын нээлттэй, ил тод байдлыг хангах /37 дугаар зүйл/

1/Төрийн аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааны тайланг өөрийн цахим хуудсанд олон нийтэд **нээлттэй, ил тод** байршуулна.

2/Төрийн аудитын байгууллага төрийн болон албаны, байгууллагын, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан журмын дагуу **улирал бүр** гаргаж, **өөрийн цахим хуудсаар олон нийтэд** мэдээлнэ.

3/Төрийн аудитын байгууллага хүсэлт гаргасан этгээдэд төрийн болон байгууллага, хувь хүний **нууцад хамаарах мэдээлэл агуулснаас бусад** аудитын тайланг хуульд заасан журмын дагуу өгч болно.

4/Аудитад иргэн, олон нийтийн мэдээллийг ашиглаж болно.

5/Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх болон хуулиар хориглосноос бусад тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний зөвшөөрснөөр төрийн аудитын байгууллагын албан хаагч аудитын тайлангийн талаар олон нийт, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгч болно.

Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх /39 дүгээр зүйл/

1/Энэ хуулийн 11.2-т заасан аудитыг гүйцэтгэхэд **төрийн аудитын байгууллагын албан хаагч** бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд **саад учруулсан, аливаа дарамт, шахалт үзүүлсэн, хууль бус нөлөөллийн талаар нөлөөллийн мэдүүлэг** хөтөлнө.

2/Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага /42 дугаар зүйл/

1/Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд */шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагч этгээд/*, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид **сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл** болно.

2/Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан нь тухайн албан хаагчийг **ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл** болно.

3/Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.

42.4.Энэ хуулийн 42.1, 42.2-т заасны дагуу тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулахад бусад хуульд заасан үндэслэл, журам үйлчлэхгүй.

42.5.Төрийн аудитын байгууллагын албан хаагч төрийн аудитын нийтлэг стандарт, ёс зүйн дүрмийг зөрчсөн, хуульд заасан албан үүргээ биелүүлээгүй бол Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**Тав.Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу
дагалдах гарах эрх зүйн актын тухай**

№	Журам, зааврын нэр	Батлах субъект	Хуулийн заалт
1	Гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын гүйцэтгэх ажилд зориулсан улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад аудит гүйцэтгэх журам	Монгол Улсын Ерөнхий аудитор	6 дугаар зүйлийн 6.4
2	Санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх журам	Монгол Улсын Ерөнхий аудитор	7 дугаар зүйлийн 7.3
3	Аудитын хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, аталгаажуулах журам	Монгол Улсын Ерөнхий аудитор	8 дугаар зүйлийн 8.7
4	Аудитад цахим мэдээллийн нэгдсэн системийг ашиглах журам	Монгол Улсын Ерөнхий аудитор	13 дугаар зүйлийн 13.4
5	Төрийн аудитын стандартын хорооны дүрэм	Монгол Улсын Ерөнхий аудитор	14 дүгээр зүйлийн 14.5
6	Төрийн аудитын байгууллагын мэдээлэл авах журам	Монгол Улсын Ерөнхий аудитор	15 дугаар зүйлийн 15.5
7	шинжээчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам	Монгол Улсын Ерөнхий аудитор	17 дугаар зүйлийн 17.6
8	Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох	Монгол Улсын Ерөнхий аудитор	21 дүгээр зүйлийн 21.4
9	Төрийн аудитын байгууллага бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний тодорхойлолт, загвар, хэрэглэх журам	Монгол Улсын Ерөнхий аудитор	24 дүгээр зүйлийн 24.5
10	Төрийн аудитын байгууллагын албан тушаалын зэрэг дэв, нэмэгдэл олгох журам	Монгол Улсын Ерөнхий аудитор	25 дугаар зүйлийн 25.5
11	Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам	Монгол Улсын Ерөнхий аудитор	39 дүгээр зүйлийн 39.2

-----oOo-----